

ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ӨСӨЛТ, ТҮҮНИЙГ ХАНГАХ АРГА ЗАМ

Ломбодоржийн Наранчимэг, доктор (Ph.D), дэд профессор, Бизнесийн Сургууль, Монгол Улсын Их Сургууль

Банздайн Сайнжаргал, доктор (Ph.D), профессор, Бизнесийн Сургууль, Монгол Улсын Их Сургууль

Хураангуй

Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд бүтээмжийн өсөлт чухал байдаг. Бүтээмж гэдэг нь нэгж зардлаар хэдий хэр бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэж байгааг харуулдаг үзүүлэлт юм. Үйл ажиллагааг оновчтой удирдан зохион байгуулж, хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай зарцуулж зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгосноор бүтээмж дээшлэх ба бүтээмжийн энэхүү өсөлт нь улс орон, түүнчлэн аж ахуйн нэгжийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж улмаар нийгмийн баялгийг нэмэгдүүлж, хүн амын амьжиргааны түвшин орлогыг өсгөдөг. Хөгжилтэй орнуудын туршлагаас харвал улс орны хэмжээнд ч, аж ахуйн нэгж байгууллагын тухайд ч, өрх гэр иргэний хувьд ч бүтээмж нь эдийн засгийн өсөлт, хөгжлийн чухал хөшүүрэг болж байна.

Байгууллагын хөдөлмөрийн нөөц түүний ашиглалтын үр ашиг болон хөдөлмөрийн бүтээмжинд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тооцож дүгнэлт өгөх нь чухал юм.

Түлхүүр үгс: Хөдөлмөрийн бүтээмж, нийт бүтээмж, үндсэн хүчин зүйлийн бүтээмж, тодорхой нэг хүчин зүйлийн бүтээмж, нэмэгдсэн өртөг, нэг ажилчны хөдөлмөрийн бүтээмж

Abstract

Productivity growth is an important on economic and social development of country. Productivity is an indicator that shows how many goods and services to be produced on the unit cost. Productivity is improved by producing quality products and services that is met market demand in a result of efficient organizing for operations and effective spending for limited resources. Thus, this growth of the productivity becomes increase in corporate competitiveness as well as social wealth and living standard. For experience of developed countries, the productivity is an important leverage for economic growth and development in case of countries, entities and households.

In a result, it is important to summarize for analyzing the effect of labor resource on the productivity and utilization efficiency of labor resources.

Key words: Labor productivity, total productivity, the main factor productivity, one factor productivity, added value, productivity for per employee

Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт

Бүтээмж нь улс оронд бий болсон үндэсний орлого, баялгийн чухал хэмжүүр бөгөөд нэгж зардлаар хэдий хэр бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэж байгааг тодорхойлдог үзүүлэлт юм. Бүтээмж бол хязгаарлагдмал нөөцөөр нийгмийн байнга өсөн нэмэгдэх хэрэгцээг хэрхэн хангах вэ? гэсэн эдийн засгийн үндсэн асуудлыг ямар түвшинд, хэрхэн үр дүнтэй шийдвэрлэж байгааг харуулдаг, аливаа үйлдвэрлэл,

үйл ажиллагаанд зарцуулах бүх төрлийн орцын ашиглалтын түвшинг илэрхийлсэн, эдийн засгийн үр ашгийн үзүүлэлт юм. Эдийн засгийн шалгуур үзүүлэлт болох хэмнэлт, үр ашиг нь эцсийн дүнд бүтээмжээр дамжин илэрдэг. Бүтээгдэхүүнийг бүтээн бий болгоход зарцуулж байгаа нөөцийг хамгийн боломжит хэмжээгээр багасгаж, энэхүү нөөцийг ашигласны дүнд бүтээгдэн бий болж байгаа гарцын хэмжээг дээд зэргээр нэмэгдүүлснээр бүтээмж өснө. Бүтээмжийн өсөлт нь амьжиргааны түвшин, инфляцид

ээрэгээр нөлөөлдөг. Эдийн засгийн бодит өсөлтийг бий болгогч тулгын гурван чулуу нь хөрөнгийн хуримтлал, ажиллах хүчний ур чадвар, технологийн хөгжлийн түвшин юм. Энэ тулгын гурван чулууг бүтээмжид нөлөөлөх нэгдсэн хүчин зүйл (Total Factor Productivity-TFP) гэдэг. Өнөөдрийн хөгжилтэй орнуудын туршлагаас мэдлэгт суурилсан нэмүү өртөг ихээр шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэдэг дэвшилтэд техник технологи бүхий боловсруулах аж үйлдвэрийн салбар болон үйлчилгээний салбар руу хөрөнгө, мэргэшсэн ажиллах хүчний шилжилт явагдаж, энэ хэмжээгээр тухайн орны бүтээмж, өрсөлдөх чадвараар хөгжлийн түвшин нь илэрхийлэгдэж байна.

Эдийн засагч П.Самуэльсон улс орнуудын хоцрогдол, буурай хөгжлийн нэг шалтгааныг бүтээмжийн түвшин доогуур байгаатай холбон тайлбарласан байдаг. Тэрээр бүтээмжийн түвшин доогуур байх нь ашиг орлого хуримтлалын хэмжээг бууруулан, улмаар капиталын хөрөнгө оруулалт хийж техник, технологи үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг хязгаарлах бөгөөд энэ нь эргээд бүтээмжийг бууруулахад хүргэдэг гэж үзжээ. Бүтээмж нь үйлдвэрлэлийн дүнд бий болсон нийт гарц, энэхүү үйлдвэрлэлийг явуулахад зарцуулсан орцын харьцаагаар тодорхойлогдоно.

$$\text{Бүтээмж} = \frac{\text{Гарц}}{\text{Орц}}$$

Гарцын үзүүлэлтүүд нь: -Үйлдвэрлэлийн хэмжээ, -Нэмэгдсэн өртөг, -Нийт ашиг, -Цэвэр ашиг гэх мэт. Орц гэдэг нь аливаа үйлдвэрлэл, үйлчилгээг явуулахад зарцуулсан зардлууд юм.


Бүтээмжийн агуулга, мөн чанарыг тодорхойлох асуудалд 2 талтай хандаж байна.

1. Бүтээмжийг арга хэрэгсэл талаас нь, өөрөөр хэлбэл, эдийн засгийн нэг үзүүлэлт болохынх нь хувьд тодорхойлох хандлага /явцуу тодорхойлолт/
2. Бүтээмжийг нийгэм эдийн засгийн үзэл баримтлал талаас, өргөн хүрээг хамарсан гүнзгий утга агуулгаар тодорхойлох хандлага /нийгэм эдийн засгийн ойлголт/

Бүтээмжийн өсөлт нь аливаа улс орны нийгэм эдийн засгийн хөгжил, дэвшил, хүн ардын амьжиргааны түвшиний дээшлэлтийн нэг гол эх үүсвэр юм.

Манай улсын хувьд хөдөлмөрийн бүтээмжийг макро түвшинд ДНБ-ээр, салбарын хэмжээнд нэмэгдсэн өртгөөр тооцдог.¹ Манай улсын ДНБ 2011-2013 онуудад 9-12 хувиар, 2013-2015 онуудад 5-9 хувиар, 2015 онд 2014 оноос 02 хувиар тус бүр өссөн нь (зураг 1) улсын хэмжээгээр хөдөлмөрийн бүтээмж нэмэгдүүлэх нөлөөллийг үзүүлж байгаа хэдий ч ажиллагчдын тоо 2015 онд 1151,0 мянган хүн болж өмнөх оныхоос 3.6 орчим хувиар өссөнөөр эцсийн дүндээ хөдөлмөрийн бүтээмж буурсан байна.

Зураг 1. ДНБ, Хөдөлмөрийн бүтээмж, Ажиллагчдын тоо (2011-2015 оноор)




Эх сурвалж: ҮСХ, Монгол улсын статистикийн эмхэтгэл 2011-2015

¹ Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2015 он 52 хуудас

Эдийн засаг 2016 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар өссөн. Уул уурхайн салбар 9.1 хувиар өссөн нь ДНБ-ий өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлжээ. Харин

сүүлийн 5 улирал дараалан уналттай байгаа уул уурхайн бус салбар өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар агшиж, өсөлтийг 0.6 хувиар (зураг 2) сааруулах нөлөө үзүүлжээ.

Зураг 2. Хөдөлмөрийн бүтээмж салбараар 2015 оны байдлаар, өсөлт бууралтын хувиар/



Эх сурвалж: YCX, Монгол улсын статистикийн эмхэтгэл 2011-2015

ДНБ-ийн өсөлтийг сааруулах нөлөө үзүүлсэн салбаруудыг авч үзвэл, 1) боловсруулах салбарын үйлдвэрлэл сүүлийн 5 улирал дараалан агшиж байгаа бөгөөд 2016 оны эхний хагас жилд 12 хувиар буурчээ; 2) хүнсний бүтээгдэхүүн, нэхмэл, кокс шахмал түлш, төмөрлөг бус бодис болон төмрийн үйлдвэрлэлийн хэмжээ буурах хандлага үргэлжилж байна². Төрөөс цаашид хөдөлмөр түлхүү ашиглаж үйлдвэрлэл явуулдаг ХАА, жижиг дунд үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэр зэрэгт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх төдийгүй үйлдвэрлэлийн секторуудад татварын хөшүүрэг (татварын түвшин нь хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлдөг гэсэн судалгаа байдаг) болон бусад бодлогын арга хэмжээг түлхүү авч хэрэгжүүлэх шаардлага байна.

Бүтээмжийн өсөлт нь дараах нөхцөлд хангагдана.

- Гарц өсч , орц буурах: хамгийн их үр дүнд, хамгийн бага зардлаар хүрэх
- Гарц өсч , орц тогтмол байх: илүү үр дүнд ижил зардлаар хүрэх
- Гарц тогтмол байж, орц буурах: ижил үр дүнд илүү бага зардлаар хүрэх
- Гарцын өсөлт, орцын өсөлтөөс давамгайлах: хамгийн их үр дүн
- Гарцын бууралтаас, орцын бууралт давамгайлах: хамгийн бага зардлын зарчим.

Бүтээмжийн онол практикт түүнийг үндсэн 3 хэлбэрээр, нийт эдийн засгийн хувьд, салбар, дэд салбар, аж ахуйн нэгжийн хувьд дараах байдлаар тооцдог.

² Монгол банк (2016). Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, 43-45 хуудас

Бүтээмж	Агуулга
1.Нийт бүтээмж (НБ)	<p>Нийт бүтээмж нь бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилгоор үйлдвэрлэлд зарцуулсан нийт зардлын нэг төгрөг тутмаас хэдэн төгрөгийн бүтээгдэхүүн бий болгож чадсаныг харуулдаг.</p> $НБ = \frac{ДНБ \text{ (нэмэгдэл өртөг)}}{Цалин \text{ (НДШ+Элэгдэл+Завсрын хэрэглээ)}}$
2.Үндсэн хүчин зүйлийн бүтээмж (ҮБ)	<p>Үндсэн хүчин зүйлийн бүтээмж нь үйлдвэрлэлийн гол хүчин зүйл болох хөдөлмөр, капиталын ашиглалтын үр ашгийг тодорхойлж, тэдгээрийн хоорондох оновчтой хослолыг харуулах ба шинжлэх ухаан, техник технологийн дэвшлийн нөлөөллийн үр дүнг илэрхийлдэг үзүүлэлт юм.</p> $ҮБ = \frac{ДНБ \text{ (нэмэгдэл өртөг)}}{\text{цалин} + \text{үндсэн хөрөнгийн элэгдэл}}$
3. Тодорхой нэг хүчин зүйлийн бүтээмж (ТБ)	<p>Тодорхой нэг хүчин зүйлийн бүтээмжийг улсын түвшинд тооцохоос гадна салбар, аж ахуйн нэгжийн түвшинд тооцож болох бөгөөд задлын төрөл тус бүрээр, тухайлбал хөдөлмөр, капитал, материал, эрчим хүчний бүтээмж байдлаар тооцож болно. Уг үзүүлэлт нь бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилгоор үйлдвэрлэлд зарцуулсан зардлын нэг төгрөг тутмаас хэдэн төгрөгийн бүтээгдэхүүн бий болгож чадсаныг харуулдаг үзүүлэлт юм. Тухайлбал, хөдөлмөрийн зарцуулалтын бүтээмж нь:</p> $\text{Хөдөлмөрийн бүтээмж} = \frac{ДНБ \text{ (нэмэгдэл өртөг)}}{\text{Хөдөлмөр}}$ <p>Хөдөлмөрийн бүтээжийг хэд хэдэн үзүүлэлтээр тооцож болно. Тухайлбал: нэг ажилчинд ногдох хөдөлмөрийн бүтээмж, нэг цагт ноогдох хөдөлмөрийн бүтээмж, нэг өдөрт ногдох ногдох хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн хөлсний нэгжид ногдох бүтээмж гэх мэт</p>

Хөгжилтэй орнуудын туршлагаас харвал, улс орны хэмжээнд ч, аж ахуйн нэгж байгууллагын тухайд ч, өрх гэр иргэний хувьд ч бүтээмж нь эдийн засгийн өсөлт, хөгжлийн чухал хөшүүрэг болж байна. Түүнчлэн, улсын хэмжээнд явагдсан цалин хөлс, бүтээмжийн судалгааны урьдчилан дүнгээс үзвэл, ААНБ-уудын түвшинд цалин хөлсийг нэмэгдүүлэхдээ бүтээмжийн өсөлтийг харгалзан үздэггүй төдийгүй бүтээмжийн ач холбогдлыг ажил олгогч, ажиллагчид нь сайн мэддэггүй дүн гарчээ³. Азийн бүтээмжийн байгууллагаас үйл ажиллагаа явуулах уриагаа “Making tomorrow better than today” гэж тодорхойлжээ. Иймээс бид ч маргаашаа өнөөдрөөс илүү сайн сайхан болгохын тулд нөөц бололцоогоо илүү үр дүнтэй ашиглаж, ахиу үр ашиг бий болгон тогтвортой үйл ажиллагааны үндэс суурийг тавих шаардлагатай төдийгүй ААНБ-ын хүрээнд

хөдөлмөрийн нөөц, түүний ашиглалтын үр өгөөжийг илүү үндэслэлтэй, бодитойгоор төлөвлөх шаардлага бий болж байна.

Байгууллагын хөдөлмөрийн нөөц түүнтэй холбогдсон хөдөлмөрийн зарцуулалт нь капитал зарцуулалтын нэг хэсэг юм. Эдгээрийн ашиглалтыг үнэлэх зорилгоор хөдөлмөрийн бүтээмжийн үзүүлэлтийг дараах хувилбаруудаар тооцдог⁴.

Үүнд:

1. Уламжлалт аргаар буюу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, эсвэл борлуулалтын орлогоор

$$ХБ1 = \frac{\text{Бүт эсвэл БО}}{\text{АТ}}$$

³ МУЗГ (2012). Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны тогтоол, 2012 оны 11 сарын 17 өдөр №05

⁴ Б.Сайнжаргал (1999). “Санхүүгийн тайлангийн шинжилгээ”, 55-р тал, Улаанбаатар

2. Шинээр бүтээгдсэн нэмэгдсэн өртгөөр

$$ХБ2 = \frac{НӨ}{ХЗ} = \frac{НӨ}{АТ} : \frac{ХЗ}{АТ} = ХБ : ДЦ$$

Нэмэгдсэн өртөг ба хөдөлмөрийн зардлын харьцаа нь зарцуулсан хөдөлмөрийн үр бүтээл болох хөдөлмөрийн бүтээмж ба цалингийн харьцааг илэрхийлнэ. Нэг ажилчны хөдөлмөрийн бүтээмжинд нөлөөлөх хүчин зүйлийг интенсив ба экстенсив хүчин зүйл гэж 2 ангилдаг. Интенсив хүчин

зүйлд нэг ажилчны дундаж бүтээл түүнд нөлөөлөх хөдөлмөр зарцуулалтын өөрчлөлт, бүтээлийн нормын биелэлт, ажилчдын ажилласан туршлага, мэргэжлийн түвшин, үйлдвэрлэлийн техникжилтийн түвшин зэрэг үзүүлэлтүүд хамаарагдана. Экстенсив хүчин зүйлд ажилчдын ажлын цагийн ашиглалттай холбоотой үзүүлэлтүүд болох ажилчдын жилд ажилласан өдөр, ажлын өдрийн буюу ээлжийн доторх цагийн ашиглалт, сул зогсол гэх мэт хөдөлмөрийн зохион байгуулалтын хүчин зүйлүүд хамаарна.

Хүснэгт 1: Хөдөлмөрийн бүтээмжийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	
			тоогоор	хувиар
1. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн(м/т)	40 450,8	44 090,7	3 639,9	108,9
2. Ажилчдын тоо	170	175	7	102,9
3. Ажилчдын ажилласан хүн өдөр	41 650	40 425	-1 225	97,0
4. Ажилчдын ажилласан хүн цаг Үүнээс илүү цагаар ажилласан хүн цаг	312 375 -	307 230 6 063	-5 145	98,3
5. Нэг ажилчны ХБ (төг): Үүнээс Жилийн (1:2) Өдрийн (1:3) Цагийн (1:4)	237 945,88 971,2 129,49	251 946,85 1 090,67 143,51	14 000,97 119,47	105,8 112,3
6. Нэг ажилчны жилд ажилласан өдөр (3:2)	245	231	-14	94,0
7. Ажлын өдрийн урт (4:3)	7,5	7,6	0,1	101,3

Эх үүсвэр: Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг үгдэслэн судлаачийн тооцооноор

Нэг ажилчны жил, өдөр, цагийн бүтээлийн өсөлтийн харьцаа нь хоорондоо хамааралтай.

$$ХБа = \Theta * У\Theta * Бц \quad ХБа = \frac{хүн өдөр}{АТоо} * \frac{хүн цаг}{хүн өдөр} * \frac{ҮБ}{хүн цаг}$$

1. ХБж >ХБө> ХБц гэсэн нөхцлийг хангаж байвал “зохистой харьцаа”гэх бөгөөд энэ нь бүтэн өдрийн болон ээлжийн доторх цагийн гарздал буурсан нөхцөлд хангагдана.
2. ХБж >ХБө< ХБц Бүтэн өдрийн ашиглалт , харин ээлжийн доторх цагийн гарздал өссөн.
3. ХБж <ХБө> ХБц Ээлжийн доторх цагийн гарздал буурч, бүтэн өдрийн гарздал өссөнийг илтгэнэ.

Эдгээр хамаарлыг үндэслэн нэг ажилчны жилийн бүтээлд нөлөөлсөн экстенсив, интенсив үзүүлэлтүүдийн нөлөөллийг ажилчдын жилд ажилласан өдөр, цагийн ашиглалт буюу өдрийн урт, цагийн бүтээлийн өөрчлөлт зэргээр нарийвчлан тооцоолж дүгнэлт өгдөг.

Дээрх жишээгээр нэг ажилчны жилийн бүтээл 14 000,97 төгрөгөөр нэмэгдсэн нь дараах хүчин зүйлүүдтэй холбоотой юм байна.

1. Нэг ажилчны ажилласан өдөр 14 өдрөөр буурснаас жилийн бүтээмж:
 $\Delta ХБ(а) = -14 * 7,5 * 129,49 = -13596,45$ төгрөгөөр буурсан.
2. Ажилчдын ажлын өдрийн урт 0,1 цагаар нэмэгдсэнээр жилийн бүтээмж
 $\Delta ХБ(өу) = 231 * 0,1 * 129,49 = 2991,22$ төгрөгөөр нэмэгдсэн
3. Ажилчдын нэг цагийн бүтээл 14,02 төгрөгөөр нэмэгдсэнээр жилийн бүтээмж:
 $\Delta ХБ(Бц) = 231 * 7,6 * 14,02 = 24606,2$ төгрөгөөр нэмэгдэх нөлөөллийг тус бүр үзүүлжээ.

Эдгээр 3 хүчин зүйлийн нөлөөлөл нь бүгд : $-13 596,45 + 2 991,22 + 24 606,2 = 14000,97$ төгрөг болсон байна.

Хөдөлмөрийн бүтээмжинд нөлөөлөгч хүчин байгууллагын зохион байгуулалтаас хамаарч зүйлүүдийг хүний нөөцийн чадавхи болон дараах 5 түвшинд ангилан судлах боломжтой.

Зураг 3. Хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлөгч хүчин зүйлүүд



Дүгнэлт

Хөдөлмөрийн бүтээмж гэдэг нь хүний нөөцийн ашиглалтын үр өгөөжийг харуулдаг гол үзүүлэлт юм. Хөдөлмөрийн бүтээмж нь нэгж хугацаанд (нэг цаг, долоо хоног, 1 сар, 1 жил гэх мэт) үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, гүйцэтгэсэн ажлын хэмжээгээр, эсвэл хөдөлмөрийн зарцуулалтын нэгж тутамд ногдох бүтээсэн өртгөөр тодорхойлогдоно. Өнөөгийн өрсөлдөөний эрин үеийн нэг чухал хүчин зүйл нь өндөр бүтээмж юм. Нөөц баялгийг зүй зохистой, үр ашигтай хуваарилан зарцуулах үйл ажиллагааг өрсөлдөхүйц түвшинд хүргэн оновчтой зохион байгуулж, бүтээмжийн өсөлтийг хангах нь аливаа улс орон, бизнесийн байгууллагын өрсөлдөх чадварын үндсэн хэмжүүр юм. Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Монгол хүний үнэ цэнэ, үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлогыг бүх салбарт баримтална гэж тусгажээ. Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх олон аргуудыг (Японы 5С, Кайзен, яг цагт нь систем, бенчмаркинг гэх мэт) манай томоохон аж ахуйн нэгжүүд туршин хэрэглэж байгаа ч, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдсэн өртгөөр нь зөв хэмжих, түүний өсөлт бууралтыг нөлөөлсөн хүчин зүйлээр нь судлан тодорхойлж, үнэлгээ дүгнэлт өгөх цаашдын бодлого, төлөвлөлтөндөө удирдлага болгон ашиглах хэрэглээ дутмаг байна.

Ашигласан материал

- Б.Сайнжаргал, (1999). “Санхүүгийн тайлангийн шинжилгээ”, Улаанбаатар
- Савицкая Г.В., (2013). “Методика комплексного анализа хозяйственной деятельности”, Москва
- Лысенко Д.В., (2007). “Экономический анализ”, Москва
- Л.Наранчимэг, (2010). “Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээний онол, арга зүйн асуудал” Улаанбаатар
- МУЗГ, (2012). Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны тогтоол, 2012 оны 11 сарын 17 өдөр №05, Улаанбаатар
- Монгол банк, (2016). Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл
- МУЗГ, (2016). Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- ҮСХ, (2011-2015). Монгол Улсын Статистикийн эмхэтгэл, 2011-2015, Үндэсний Статистикийн Хороо, Улаанбаатар
- Thomas R. Robinson, Elaine Henry, Wendy L. Pirie, Michael A. Broihahn, (2012). “International Financial Statement Analysis” by CFA

Интернэт хуудас

<http://www.khun.gov.mn/>

<http://www.legalinfo.mn/>

<http://zasag.mn>

<http://cpaclass.com/fsa/ratio-01a.htm>